



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Үнэн ба зөв нам (ҮБЗН)-ын дүрмийн
нэмэлт, өөрчлөлтийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, Э.Золзаяа, Ц.Оч, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Үнэн ба зөв нам (ҮБЗН)-ын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч М.Батсуурийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Үнэн ба зөв нам (ҮБЗН)-ын үүсгэн байгуулагч А.Отгонбаатараас “... Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, намын дүрмийн 4 дүгээр бүлгийн 4.9.1-д заасны дагуу намын Их хурал нь намын дүрэм, мөрийн хөтөлбөр батлах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрхтэй байгууллага болно. Иймд намын Их хурлаас намын даргад үүрэг болгосны дагуу намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэхээр Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасны дагуу Монгол Улсын дээд шүүхэд хуулийн хугацаанд хүргүүлж, бүртгүүлэх хүсэлт гаргаж байна” гэх өргөдлийг 129 хуудас баримт, 1 ширхэг сиди, 1 ширхэг флашны хамт 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлжээ.

Дээрх өргөдөл, хавсралт баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлэн, сонсох ажиллагааг явуулж, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Үнэн ба зөв нам нь хуульд заасан хугацааны дотор өөрийн намын хөтөлбөр, дүрмийг шинэчлэн Улсын дээд шүүхэд 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр өргөдөл ирүүлсэн боловч тодорхой алдаа, зөрчилтэйн улмаас тухайн дүрмийг бүртгээгүй байна.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар зөрчлөө зассаны үндсэн дээр дахин нэг удаа 60 хоногийн дотор намын дүрмээ бүртгүүлэх боломжийг олгосны дагуу тухайн нам нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д заасан шаардлагад нийцүүлэн дүрмээ баталсан байх тул Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Үнэн ба зөв намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэв.

Нэг.Намын удирдах дээд байгууллага болох Их хурлыг зарлан хуралдуулсан процессын талаар:

Үнэн ба зөв намын дүрмийн (цаашид “Дүрмийн” гэх) 4.7-д “Намын дарга намын ээлжит бус Их хурлыг хуралдуулах саналыг Удирдах зөвлөлд оруулж болох бөгөөд саналыг Удирдах зөвлөл 14 хоногийн дотор хэлэлцэж ээлжит бус Их хурал хуралдуулах шийдвэр гаргана”, 7.7.5-д “Намын бүх шатны удирдах дээд байгууллагын бүрэлдэхүүн, ... нэр дэвшигчийг сонгох, тодруулах дотоод сонгуулийн журам батлах” гэж тус тус заажээ.

Өргөдөлд хавсаргаж ирүүлсэн баримтуудаас үзвэл, Үнэн ба зөв намын үүсгэн байгуулагч А.Отгонбаатараас 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Санал хүргүүлэх тухай” 001/012 дугаар албан бичгээр “... Намын Их хурал хуралдуулах саналыг намын дүрмийн дагуу шийдвэрлэж, намын Их хурал хуралдах цаг хугацааг тогтоолгохоор Удирдах зөвлөлд ...” хандсан байна.

Тус намын Удирдах зөвлөл нь 2026 оны 02 дугаар сарын 03-ны өдөр хуралдаж, “Намын Их хурал хуралдуулах тухай” 04/01 дүгээр шийдвэрээр Их хурлыг 2026 оны 03 дугаар сарын 07-ны өдөр хуралдуулахаар товлож, Байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 02/11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Намын Их хурлын төлөөлөгч сонгох журам”-ын дагуу Их хурлын 91 төлөөлөгчийг сонгох, хурал зохион байгуулахыг намын Байнгын хороонд даалгажээ.

Удирдах зөвлөлийн хуралд 9 гишүүн оролцохоос 8 нь оролцсон, гишүүдийн нэрсийг намын хувийн хэрэгт авагдсан Удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэл болон хуралд оролцсон 9 гишүүний нэрстэй тулгахад бүгд таарсан тул хуралд оролцох эрх бүхий этгээдүүд оролцсон байна.

Улмаар Байнгын хорооны 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хурлаас намын дэргэдэх бодлого судалгааны хүрээлэн, нийслэлийн намын хороо, аймгийн намын хороод, дүүргийн намын хороодод Их хурлын төлөөлөгчийг сонгож, 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор нэрсийг ирүүлэхээр тогтоосны дагуу Нийслэлийн намын хорооноос 9, Бодлогын судалгааны хүрээлэнгээс 9, Аймгийн намын хорооноос 28, Дүүргийн намын хорооноос 20, Сонгуульт албан тушаалтнууд 25, нийт 91 төлөөлөгчийг тус тус оролцуулахаар сонгосон нь “Намын Их хурлын төлөөлөгч сонгох журам”, намын дүрмийн 4.1-д “Намын удирдах дээд байгууллага

нь намын Их хурал байна. Намын Их хурлын төлөөлөгчид нь намын сонгуульт албан тушаалтнууд болон анхан, дунд шатны нэгжүүдээс сонгогдсон намын гишүүдээс бүрдэнэ”, 4.2-т “Дараах сонгуульт албан тушаалтнууд нь намын их хурлын төлөөлөгчид байна ...” 4.3-т “Намын анхан болон дунд шатны нэгж, намын дэргэдэх бодлого судалгааны хүрээлэнгээс дараах тооны гишүүдийг их хурлын төлөөлөгчөөр сонгоно ...”, 4.4-т “Намын их хурлын төлөөлөгчдийг сонгохдоо 30-аас доошгүй хувь нь эмэгтэй гишүүн байх зарчмыг баримтална” гэж заасантай тус тус нийцсэн байна.

Түүнчлэн, Байнгын хорооноос намын Их хурлын 91 төлөөлөгчдөд хурлын товыг утсаар мэдэгдэж, намын фейсбүүк хуудсаар дамжуулан “ҮБЗН-ын ээлжит бус Их хурлын тов, хаяг байршлын талаар мэдээлсэн, энэ талаар холбогдох баримтыг өргөдөлд хавсарган ирүүлсэн.

Үнэн ба зөв намын Их хурал нь 2026 оны 03 дугаар сарын 07-ны өдөр танхимын хэлбэрээр зохион байгуулагдаж, хуралд сонгогдсон болон ардчилсан зарчмаар томилогдсон 91 төлөөлөгчөөс 80 төлөөлөгч (87.9%) оролцсон болох нь өргөдөлд хавсарган ирүүлсэн ирцийн бүртгэл, фото зураг, дүрс бичлэг болон бусад баримтаар тогтоогдсон, энэ нь дүрмийн 4.8-д “Намын Их хурлыг нийт төлөөлөгчдийн олонх нь оролцсоноор хүчинтэйд тооцно” гэж заасантай нийцсэн байна.

Хоёр. Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан талаар:

Өмнө нь, Үнэн ба зөв намын Удирдах зөвлөл нь 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хуралдаж, намын Ээлжит бус II Их хурлыг 2025 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдуулахаар тов тогтоосны дагуу Их хурал хуралдаж, 07 болон 20 дугаар тогтоолоор намын хөтөлбөр, дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг баталж, Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр ирүүлсэн байх бөгөөд хурлын процессын хувьд зөрчилгүй боловч дүрмийн зарим заалт нь “Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцээгүй” гэж 7 үндэслэл бүхий 16 зөрчлийг дурдаж, Улсын дээд шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 02/356 дугаар албан бичгээр өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг буцаасан байна.

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гээд 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж;

Үнэн ба зөв намын дүрэм (2017 он)-ийн 1.3-т “Нам нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.” гээд 1.3.3-т “Зохион байгуулалт, үйл ажиллагаагаар ардчилсан зарчимд тулгуурлан цөөнхийн саналд хүндэтгэлтэй хандаж, олонхын саналаар гаргасан шийдвэрийг нийтээрээ даган биелүүлж, эв нэгдлийг эрхэмлэн ажиллах”, 4.9-д “Намын Их хурал нь дараах онцгой бүрэн эрхтэй:”, 4.9.1-д “Намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж тус тус заажээ.

Үнэн ба зөв намын Их хурал 2026 оны 03 дугаар сарын 07-ны өдөр дахин хуралдаж, намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж, хуралдаанд оролцсон 80 төлөөлөгчийн 100 хувийн саналаар дэмжин баталсан нь Тооллогын комиссын 2026 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоол, Их хурлын

“Намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг батлах тухай” 06 дугаар тогтоол, хуралдааны тэмдэглэл болон өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтаар тогтоогдож байна.

Тус намын дүрэм нь Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл, Хоёрдугаар бүлэг. Намын гишүүнчлэл, Гуравдугаар бүлэг. Намын анхан болон дунд шатны байгууллага, Дөрөвдүгээр бүлэг. Намын удирдлага, Тавдугаар бүлэг. Намын төв хороо, Зургадугаар бүлэг. Намын дарга, Долдугаар бүлэг. Намын байнгын хороо, Наймдугаар бүлэг. Намаас сонгуульд нэр дэвшигчийг тодруулах, Есдүгээр бүлэг. УИХ дахь намын бүлэг, Аравдугаар бүлэг. Намын өмч хөрөнгө, татвар, Арван нэгдүгээр бүлэг. Хариуцлагын хороо, Арван хоёрдугаар бүлэг. Намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, Арван гуравдугаар бүлэг. Намыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай гэсэн нийт 13 бүлгээс бүрдсэн байх бөгөөд Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана” гээд 15.2.1-15.2.10-т заасан намын дүрэмд тавигдах шаардлагад нийцжээ.

Үнэн ба зөв намын Их хурлын 2026 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Улсын дээд шүүхийн 2026 оны 02/356 дугаар албан бичигт дурдсан “намын дүрэмд хариуцлагын ерөнхий хороо, маргаан хянан шалгах зөвлөл, маргаан хянан шийдвэрлэх зөвлөл гэсэн хоорондоо зөрүүтэй нэр томьёотой тусгасан нь ойлгомжгүй гэсэн тогтоолын зөрчил арилаагүй; хяналтын төв байгууллага болох Хариуцлагын хорооны гишүүнээр хяналтын байгууллагын гишүүн бус хүнийг сонгох нь ойлгомжгүй; төрөөс олгосон санхүүжилтийг намын салбар болон бүтцийн нэгжид хуваарилахгүй гэж заасан нь буруу; намын хөрөнгө, орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг намын Төв хороо батлан мөрдүүлэх, намын татвар, хураамжийг тогтоох, санхүүжилтийн журмыг батлахыг намын Байнгын хорооны эрхэд хамааруулсан нь чиг үүргийн хувьд давхцалтай; намын дэргэд өөр аливаа бие даасан хуулийн этгээд байгуулж ажиллахыг хориглоно гэж заасан атлаа намын дэргэдэх академийн ажиллах журмыг Төв хорооноос батална гэсэн нь ойлгомжгүй; хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, 42 дугаар зүйлийн 42.4-т заасныг намын дүрэмдээ тусгаагүй; Хариуцлагын хорооны гишүүдийг нөхөн сонгох эрх намын төлөөллийн төв байгууллага буюу Төв хороонд байна гэсэн нь хууль болон дүрэмд нийцээгүй; Байнгын хороог байгуулах хугацааны хувьд “4 жил”, “2 жил” гэж, тухайн бүрэлдэхүүнийг байгуулахдаа “сонгох”, “томилох” гэж өөр өөрөөр, зөрүүтэй байдлаар тусгасан; дүрмийн 13.3, 13.4 дэх заалтууд нь хуульд нийцэж буй эсэх; санхүүгийн тайланг хянан шалгах дотоод аудиторыг нөхөн томилох, салбар нэгжийн даргыг сонгох, чөлөөлөх асуудлыг, намын гишүүн хугацаандаа татвараа төлөөгүй тохиолдолд авах арга хэмжээ, татвараас хөнгөлөх, чөлөөлөх эсэх, сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх болон сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа, үр дагаврын талаар намын дүрэмд тодорхой тусгаагүй” алдаа зөрчлүүдийг дараах байдлаар зассан байна.

Намын дүрмийн 2.17.2-т “Гурван сарын хугацаанд гишүүн алдаа дутагдлаа зассан бол Хариуцлагын хороо сахилгын шийтгэлийг цуцална” гэж;

-3.12-т “Аймаг, нийслэлийн буюу дунд шатны даргыг байнгын хорооны санал болгосноор тухайн шатны бүх гишүүдийн хурлаар 4 жилийн хугацаатай сонгоно. Намын анхан шатны даргыг харьяа дунд шатны намын даргын санал болгосноор, тухайн анхан шатны байгууллагын хурлаар 4 жилийн хугацаатай сонгоно” гэж;

-3.13-т “Анхан болон Дунд шатны намын даргыг ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэж байна гэж намын байнгын хороо үзэж хугацаанаас өмнө огцруулах санал гаргаж болно. Огцруулах саналыг тухайн намын анхан, дунд шатны бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж олонхын саналаар шийдвэрлэнэ” гэж;

-5.15-д “Намын санхүүгийн тайланг хянан шалгах нэг, эсхүл түүнээс дээш тооны дотоод аудиторыг намын төлөөллийн төв байгууллагаас дөрвөн жилийн хугацаатай томилно. Түүнийг нэг удаа улируулан томилж болно. Намын дарга Төв хороонд дотоод аудиторыг санал болгож оруулж ирнэ” гэж;

-7.2-т “Байнгын хороо нь намын даргыг оролцуулан 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр Төв хорооны гишүүдийн нууц санал хураалтаар намын Их хурлын бүрэн эрхийн хугацаанд 4 жилийн хугацаагаар сонгоно ...” гэж;

-10.5-т “... Намын гишүүний татвар сайн дурын байх тул татвар төлөөгүй тохиолдолд арга хэмжээ тооцож үл болно” гэж;

-10.28-д “Нам нь энэ дүрмийн 10.25-д, хуульд заасан хориглосон этгээдээс хандив авсан бол хандив хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор тухайн хандивлагч болон сонгуулийн төв байгууллагад энэ тухай мэдэгдэж, хандивыг сонгуулийн төв байгууллагад шилжүүлэх; шилжүүлээгүй бол намын ерөнхий нарийн бичгийн дарга хариуцлага хүлээнэ”, 10.35-д “Намын болон анхан, дунд шатны нэгжид санхүүгийн тайланд алдаа зөрчил гаргасан, гаргасан алдаа, зөрчлийг засаж залруулаагүй бол зөрчлийг гаргасан этгээдэд намын дүрэмд заасан сахилгын хариуцлага хүлээнэ” гэж;

-10.29-д “Төрөөс олгосон санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг намын салбар болон бүтцийн нэгжид олгоно. Ингэхдээ байгуулагдсан салбар нэгжид тэнцүү хувааж олгоно” гэж;

-11.2-т “Намын Хариуцлагын хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй, 4 жилийн хугацаатайгаар намын Их хурлаас сонгож байгуулна. Хариуцлагын хорооны бүрэлдэхүүнд эрэгтэй, эмэгтэй аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна” гэж;

-11.5-д “Хариуцлагын хорооны гишүүнээр намын төлөөллийн, гүйцэтгэх байгууллагын гишүүн бус, намын ажлын албаны ажилтан бус 30-аас дээш настай гишүүнийг сонгох бөгөөд нэг удаа намын Их хурлаар улируулан сонгож болно” гэж;

-13.2-т “Намын нэрийг өөрчлөх, өөрчлөн байгуулах, намын үйл ажиллагааг нь зогсоох тухай шийдвэрийг гагцхүү намын Их хурал гаргах бөгөөд намыг өөрчлөн байгуулах, намын үйл ажиллагааг зогсоох тухай асуудлыг намын нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь санал гаргасан тохиолдолд намын Их хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ”, 13.3-т “Энэ дүрмийн 13.2-т заасан шийдвэр гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд эцсийн шийдвэр байна. Уг шийдвэрийн хэрэгжилт, үр дагаврыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна”, 13.4-т “Нам татан буугдвал, үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргасан бол намын өр төлбөрийг барагдуулж дууссаны дараа үлдсэн өмч хөрөнгийг сонгуулийн төв байгууллагад шилжүүлнэ” гэж тусгаж, харин дээрх албан бичигт дурдсан зарим зөрчилтэй дүрмийн заалтыг хассан байна.

2026 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн сонсох ажиллагааны явцад Үнэн ба зөв намын үүсгэн байгуулагч А.Отгонбаатараас “намын дүрмийн 7.9.15 дахь заалтыг Намын Их хурлаас Байнгын хороонд даалгасан бусад эрх, үүрэг гэдэг нь журам боловсруулах, чиглэл өгсөн ажлуудыг хэлнэ. Их хурлын онцгой бүрэн эрх шилжихгүй, намын гишүүнд сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх хугацааны талаар дүрмийн 2.17.2-т заасан 3 сарын хугацаанд гишүүн алдаа дутагдлаа зассан бол Хариуцлагын хороо сахилгын шийтгэлийг цуцлах хугацаа хамаарна, хуулиар Их хурлаас Төв хороо болон Хариуцлагын хороог сонгох ёстой учраас Хариуцлагын хорооны гишүүдийг 4 жилийн хугацаагаар нөхөн сонгохгүй байгуулна ...” гэсэн агуулгаар холбогдох хуулийн заалтыг тодруулсныг дурдах нь зүйтэй.

Үнэн ба зөв намын дүрэм нь Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан байх тул бүртгэхээс татгалзах үндэслэл тогтоогдоогүй болно.

Иймд, Үнэн ба зөв намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэх нь зүйтэй байна.

Үнэн ба зөв намын хөтөлбөр хуульд нийцсэн болохыг дурдав.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5 дахь хэсэгт заасныг баримтлан Үнэн ба зөв нам (ҮБЗН)-ын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

М.БАТСУУРЬ